БАТЛАВ.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА А.ГАНЗУУЗАЙ

2024.11.01

# ГЭР ХОРООЛЛЫН ХАЯГЖУУЛАЛТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар ӨМДЗСЗДТГ/20240101036

| Д/д | Ажлын нэр, төрөл | Тайлбар |
|---|---|---|
| 1. | Ажлын үндэслэл | - Монгол улсын Хаягжуулалтын тухай хууль;<br>- Засгийн Газрын 2013 оны 323 дугаар тогтоол;<br>- Засгийн газрын 2019 оны 325 тоот тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”<br>Даланзадгад сумын Хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний 2.5.72 дахь заалт<br><br>-Монгол улсын “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283:2022 стандарт |
| 2. | Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал | Иргэдийг тухайн обьектод саадгүй, түргэн шуурхай хүрэхэд зориулан хаягийн тэмдгийг стандартын дагуу үйлдвэрлэж, хаягийн зурагт заасан байршилд газар дээр нь суурилуулахад оршино. |
| 3. | Хамрах хүрээ, талбайн хэмжээ /га/ | Хаягжуулалтын тухай хууль болон журмын дагуу хийгдсэн Даланзадгад сумын шинээр байгуулагдсан хаягжуулалт хийгдээгүй гэр хорооллуудыг захиалагчтай зөвшилцөнө. |
| 4. | Ажил гүйцэтгэх хугацаа | Тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний хугацаагаар |
| 5. | Гүйцэтгэх ажлын хэмжээ | **Шинэ стандартаар хийгдэх хаягжуулалтын хэмжээ:**<br>• Эхлэл ба төгсгөлийн хаяг нь: 500мм : 150мм<br>• Хашаан дээрх хаяг: 300мм : 150мм<br><br>**Хуучин стандартаар хийгдэх хаягжуулалтын хэмжээ:**<br>• Хашааны хаалган дээрх хаяг: 500мм : 150мм<br><br>№ \| Хаягын нэр \| хэмжих нэгж \| тоо хэмжээ<br>1 \| Шинэ стантартын хаяг \| ш \| 1112<br>2 \| Хуучин стандартын хаяг \| ш \| 4072<br>3 \| Эхлэл ба төгсөглийн хаяг \| ш \| 48 |

| | | |
|---|---|---|
| | | |
| 6. | Ажлын иж бүрдэл | 1. Холбогдох хаягийн өгөгдөл, мэдээллийг Өмнөговь аймгийн ГХБХБГазраас хүлээж авч,тулган шалгаж дутуу мэдээллийг нэмж оруулах,<br>2. Монгол улсын “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283:2014 стандартын дагуу үйлдвэрлэх,<br>3. Захиалагчаар үйлдвэрлэсэн тэмдэгүүдийг стандартын шаардлага хангасан эсэхийг шалгуулах,<br>4. Шалгаж зөвшөөрсөн тэмдэгийг хаягийн зурагт заасан байршилд, суурилуулах,(стандартын дагуу)<br>5. Ажил гүйцэтгэх үед хаяган дээрээ байгаагүй хашааны хаягыг захиалагч болон ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгнө.<br>6. Гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх,<br>7. Суурилуулсан хаягийн тэмдэгийг холбогдох этгээдэд хүлээлгэн өгч хадгалж, хамгаалах гэрээг захиалагчтай хамтран байгуулах,<br>8. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан<br>9. Суурилуулсан хаягийн тэмдгийн солбицол,газар дээр байрлуулсан схем, болон фото зураг /shp,jpg |
| 7. | Техникийн шаардлага | **Хаягийн тэмдэгт тавих шаардлага**<br>- Хаягийн тэмдгийн загвар, хэлбэр хэмжээ, өнгийг MNS 5283:2014 стандартын<br>- Бичлэгийг MNS ISO 3098–6:2003, MNS ISO 3098-2:2003 стандартын дагуу хийнэ.<br>- Хаягийн тэмдгийн бичлэгт гудамж, өргөн чөлөө,талбай, хотхон, барилга гэсэн үгнүүдийг товчлохдоо MNS 6275:2011<br>**Мөрдөх норм, дүрэм**<br>- 2019 оны Засгийн газрын 325 дугаар тогтоол “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”<br>- Монгол улсын “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283:2014 стандарт<br>**Техникийн шаардлага**<br>- Хаягийн самбарын материал нь MNS 5283:2014 стандартад заасны дагуу байгалийн үзэгдэлд тэсвэрлэхүйц, зэвэрдэггүй метал байх эсвэл хамгаалалтын зориулалтын гадаргуутай байна.<br>- Гудамжны, хашааны хаалганы хаягийн тэмдэгийн зузаан нь 1-2мм, бусад тэмдэгийн зузаан нь 3-5мм байна. Гудамжны эхлэл төгсгөл дээрх хаягийн тэмдгийг хашаан дээр байрлуулна.<br>- Хашааны хаалганы тэмдэгийг явган хаалганы баруун талд стандартад дурьдсан хэмжээнд хадна.<br>- Хаягийн тэмдгийн дэвсгэр ньRGB(0.131.73)код бүхий ногоон өнгөтэй, байгалийн аливаа үзэгдэлд хуурч гандахгүй, шөнийн цагт саадгүй харагдах, тээврийн хэрэгслийн болон бусад төрлийн гэрлийн тусгалаар гэрэлтдэг материал байна.<br>- Хаягийн самбарыг ангилал төрлөөс хамааран стандартад заасан хэмжээгээр хийж гүйцэтгэсэн байна. |

| | | |
|---|---|---|
| | | - Хаягийн тэмдэг нь гүйцэтгэгч 3-4 жилийн баталгаа гаргаж өгөхүйц чанартай байна.<br>- Гүйцэтгэсэн ажлын талаар дэлгэрэнгүй тайланд тодорхой тусгасан байна. |
| 8. | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | 1. Монгол улсын хууль, эрх зүйн орчинд нийцсэн байх,<br>2. Хаягжуулалтын стандартад нийцсэн байх,<br>3. Геодези, зураг зүйн үйлдвэр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байх<br>4. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг баримталсан байх,<br>5. Хаягийн төлөвлөлтийн болон нийтийн хэрэгцээний зураг нь зохих масштабын байр зүйн зургийн нарийвчлалыг хангасан байх. |
| 9. | Ажлын хяналт, шалгалт | Техник хяналтын зардлыг Геодези зураг зүйн ажлын жишиг үнэ номны 4.7-г баримтлан төсөвт өртөгийн 6 хувиар тооцно.<br>- Аймгийн ГХБХБГ-ын холбогдох хэлтэс нь мэргэжлийн удирдлага, заавар арга зүйгээр хангаж, ажлын гүйцэтгэлд хяналт тавина<br>- Аймгийн ГХБХБГ-ын Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Захиалагчийн техник хяналт хийнэ.<br>- Хаягийн тэмдэг болон хаягийн зургийн самбарыг туршилт хийн шалгаж стандартын шаардлага ,техникийн шаардлага хангасан тохиолдолд хүлээн авна.<br>- Туршилтын ажлын хэмжээ ба түүний үе шатууд нь тухайн тэмдгийн болон самбарын техникийн нөхцлөөс хамаарна. |
| 10. | Баримтын төвд хүлээлгэн өгөх материал | 1. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан тоон болон хэвлэмэл байдлаар - 1%,<br>2. Суурилуулсан хаягийн тэмдгийг хаягийн мэдээллийн санд оруулах, хэмжилт зураглалын ажил гүйцэтгэх, газар дээр байрлуулсан схем, болон фото зургийг тоон /shp,jpg байдлаар/ -2%, |
| 11. | Захиалагч байгууллага | Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар |
| 12. | Гүйцэтгэгч байгууллага | - Сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуй нэгж |
| 13. | Шаардагдах хөрөнгийн эх үүсгэвэр | Орон нутгийн хөгжлийн сан |
| 14. | Даалгаварт тусгагдаагүй ажил | Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ. |

<u>БОЛОВСРУУЛСАН:</u>
ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОНХС-Н ТӨЛӨВЛӨЛТ
ХАРИУЦСАН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН Ч.ЛХАГВАЦЭРЭН